

# ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТНУУДЫН ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтнүүд 2016 оны 11 дүгээр сарын 09-ны байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

## **1. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР**

ТӨБЗГ-ЫН 2016 оны 9, 10-р сард батлагдсан төлөвлөгөөний дагуу 8 төрийн өмчит хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхээр төлөвлөсөнөөс 5 байгууллага дээр шалгалт хийж дууссан, 2 байгууллага дээр шалгалтын ажил хийгдэж байгаа, 1 байгууллага шалгалтын ажил хийгдээгүй явж байгаа нь тайлангийн хугацаанд 3 байгууллага буюу “Монголын цахилгаан холбоо” ХК, ДБҮААЭГ, “Засгийн газрын авто бааз” УТҮГ нийт төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Шалгалтын явцыг авч үзвэл нийт 10 байгууллагаас 4 байгууллагын шалгалтын дүнг нэгтгэн боловсруулж, ТӨБЗГ-ЫН хуралд оруулахаар материалыг хүргүүлсэн ба 4 байгууллага буюу Буянт ухаа нисэх онгоцны “Чингис хаан” буудал, “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ХК, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ, “Цагаан шонхор” ТӨҮҮГ-ЫН шалгалтын тайлан боловсрогох шатандaa явж байгаа ба 2 байгууллага буюу “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК, “Буянт ухаа спортын ордон” ТӨҮҮГ-уудад баримтын шалгалт хийгдэж байна.

## **2. ШАЛГАЛТЫН ДҮНГИЙН ТАЛААР**

Шалгалтад хамрагдсан 4 хуулийн этгээдийн тайланг ТӨБЗГ-ЫН хуралд танилцуулах байсан боловч “Оргил рашаан сувилал” ТӨХХК, “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар” ТӨҮҮГ-ЫН шалгалтын тайланг тодорхой шалтгаанаар дараагийн хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн.

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ЫН түрээсийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайланг ТӨБЗГ-ЫН 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралд танилцуулж, “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоол гаргуулав.

Шалгалтын дүнгээр тус байгууллага дээр төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн 11 түрээсийн гэрээг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй байгуулсан, нийт 1,2 тэрбум төгрөгийн түрээсийн орлого олж түүнээс төсөвт төвлөрүүлэх 236 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн.

Тогтооолоор “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ЫН гүйцэтгэх захиралд шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч, 2017 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс зохих журам, эрх зүйн актын дагуу түрээсийн орлогыг төвлөрүүлж ажиллахыг даалгалаа.

Мөн “Буянт ухаа олон Улсын нисэх буудал” ТӨҮГ дээр шалгалт хийх явцад илэрсэн “Татваргүй барааны дэлгүүр”-ийн түрээсийн орлого болох 195,6 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллав.

## **3. ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТАЛААР:**

А. 2016 оны 11 сарын хяналт, шалгалтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө боловсруулан хэлтсийн төлөвлөгөөнд нэгтгүүлэв.

Б. Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөртэй уялдуулан Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн ажилтнуудад цахимаар өгч танилцуулан, ажилтнуудаас тоо хэмжээ, чанарын үзүүлэлтүүдийн талаар ирүүлсэн мэдээллийг нэгтгэн удирдлагад танилцуулан, хүлээлгэж өгөв.

#### **4. ТӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР**

Б. ТӨБЗГ-ын хуралд төрийн өмчийн эд хөрөнгийн зохицуулалттай холбоотой 17 байгууллагын асуудлыг бэлтгэн танилцуулж, 9 тогтоол гаргуулан, холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна. Үүнд:

- 1 тэрбум 279,3 сая төгрөгийн 18 ширхэг автомашиныг байгууллагуудаас татан төвлөрүүлэх, хуваарилах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, автомашиныг шилжүүлэх тлаар санал боловсруулан газрын хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав.
- 20 нэрийн 59 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг шилжүүлэх, 23 нэрийн 51,6 сая төгрөгийн хөрөнгийг актлах талаар санал боловсруулан газрын хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав.
- Аж үйлдвэрийн яамыг татан буулгах ажлын хэсэгт ажиллаж тус яамны үндсэн болон эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 1 тэрбум 533,8 сая төгрөгийн хөрөнгийг нийт 9 байгууллагад шилжүүлэх санал боловсруулан газрын хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав.

#### **5. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН ТАЛААР:**

Говьсүмбэр, Баянхонгор, Орхон аймгийн тооллогын дүн нэгтгэлийг холбогдох маягтын дагуу гарган хүлээлгэн өгсөн ба Булган аймгийн дүн нэгтгэл хийгдэж байна.

Нийслэлийн Сүхбаатар дүүрэг, ХХЕГ-ын тооллогын ажилд оролцож хариуцсан байгууллагуудын тооллогын материал хүлээн авах, нэгтгэх ажлууд хийгдэж байна.

Хянасан:

ТӨБХХ-ийн дарга

Ч.Түвшинзаяа

Боловсруулсан:

ТӨБХХ-ийн хяналт, шалгалт  
хариуцсан мэргэжилтэн

Д.Сувдмаа

ТӨБХХ-ийн хяналт, шалгалт  
хариуцсан мэргэжилтэн

С.Энхзориг

Төрийн өмчтөх хуулийн этгээдийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд  
баримтын хяналт, шалгалтын ажлын явц

| №  | Байгууллагын нэр                                     | Шалгалт хийх хугацаа /хэднээс хэдэн хүртэл/ | Шалгалт хийх хоног | Шалгалтын хамрах хүрээ         | Шалгасан мэргэжилтний нэр /ахлах/        | Шийдвэрлэсэн байдал  |
|--|--|---|--------------------|--------------------------------|--|--|
| <b>2016 оны төлөвлөгөөт хяналт, шалгалтын талаар</b>     |  |   |                    |                                |  |  |
| 1  | "Чингис хаан олон улсын нисэх буудал" ТӨҮГ           | 9/29-10/12                                  | 14                 | 2015-2016 оны эхний хагас жил  | Н.Ган-Эрдэнэ                             | ТӨБЗГ-ын хуралдаанд шалгалтын дүнг танилцуулахаар бэлтгэсэн  |
| 2  | "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ                    | 9/7-9/21                                    | 14                 | 2015-2016 оны эхний хагас жил  | Ө.Батбаатар,<br>Н.Ган-Эрдэнэ             | ТӨБЗГ-ын хуралдаанд шалгалтын дүнг танилцуулахаар бэлтгэсэн  |
| 3  | "Авто замын тоног төхөөрөмжийн түрээс" ТӨХК          | 10/17-10/25                                 | 7                  | 2015-2016 оны эхний хагас жил  | Д.Сувдмаа                                | ТӨБЗГ-ын хуралдаанд шалгалтын дүнг танилцуулахаар бэлтгэсэн  |
| 4  | "Оргил рашаан сувилал" ТӨХК                          | 9/14-9/23                                   | 10                 | 2015-2016 оны эхний хагас жил  | Ө.Батбаатар,<br>Д.Сувдмаа                | ТӨБЗГ-ын хуралдаанд шалгалтын дүнг танилцуулахаар бэлтгэсэн  |
| 5  | "Цагаан шонхор" УТҮГ                                 | 10/31-11/05                                 | 5                  | 2015-2016 оны эхний хагас жил  | Н.Ган-Эрдэнэ                             | Шалгалт явагдаж байгаа   |
| 6  | "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК                     | 10/31-11/15                                 | 12                 | 2015-2016 оны эхний хагас жил  | Ө.Батбаатар,<br>Д.Сувдмаа,<br>С.Энхзориг | Шалгалт явагдаж байгаа   |
| <b>2016 оны төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын талаар</b> |  |   |                    |                                |  |  |
| 7  | "Монголын цахилгаан холбоо" ТӨХК                     | 9/30-10/12                                  | 13                 | 2015-2016 оны эхний хагас жил  | Ө.Батбаатар,<br>С.Нансалмаа              | ТӨБЗГ-ын хуралдаанд шалгалтын дүнг танилцуулахаар бэлтгэсэн  |
| 8  | "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" УТҮГ | 9/25-10/04                                  | 7                  | 2015-2016 оны эхний хагас жил  | Ө.Батбаатар                              | ТӨБЗГ-ын хуралдаанд шалгалтын дүнг танилцуулахаар бэлтгэсэн  |
| 9  | "Засгийн газрын авто бааз" УТҮГ                      | 10/21-10/22                                 | 2                  | Түрээсийн үйл ажиллагаа        | С.Энхзориг                               | "ЗГАБ" УТҮГ-ын түрээсийн үйл ажиллагаанд шалгалт явуулж, ТӨБЗГ-ын 2016.11.08-ны өдрийн хуралдаанаар "Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай" 133 дугаар тогтоол гарч, зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгсэн |
| 10   | "Геологийн төв лаборатори" ТӨҮГ                      | 10/26-10/28                                 | 3                  | 2016 оны 3-р улирлын байдлаарх | С.Энхзориг                               | ТӨБЗГ-ын хуралдаанд шалгалтын дүнг танилцуулахаар бэлтгэсэн  |

Хянасан:

Боловсруулсан:

Ц.Түвшинзая /ТӨБХХ-ийн дарга/  
Ө.Батбаатар /ТӨБХХ-ийн ахлах мэргэжилтэн/

Д.Сувдмаа /ТӨБХХ-ийн мэргэжилтэн/  
С.Энхзориг /ТӨБХХ-ийн мэргэжилтэн/